



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Есөнбулаг сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ГАА-2022/106/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор Р.Цанжидмаа Утас: 99029885 Цахим хаяг: tsania.0215@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
3. Аудитын тайлан .....	7
3.1 Ерөнхий зүйл .....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	8
3.4 Материаллаг байдал .....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	10
3.8 Аудитын гол асуудал.....	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
4. Аудитын илрүүлэлт.....	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	12

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЕСӨНБУЛАГ  
СУМЫН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ С.ДАВААЦЭРЭН ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25 № 75  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

07020083

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>135,297,351.47</b>	<b>143,470,915.47</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	10,540.40	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	10,540.40	
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	135,286,811.07	143,470,915.47
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	175,000.00	244,600.00
35130	Эм боох материал	175,000.00	244,600.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	135,111,811.07	143,226,315.47
35410	Бичиг хэргийн материал	-	354,000.00
35420	Аж ахуйн материал	97,490,958.90	94,980,292.90
35460	Хүнсний материал	3,360,460.00	3,565,262.00
35470	Бусад хангамжийн материал	34,260,392.17	44,326,760.57
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,018,476,613.22</b>	<b>983,534,544.41</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,018,476,613.22	983,534,544.41
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	879,124,113.22	844,369,544.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	880,403,192.90	880,403,192.90
39202	Хуримтлагдсан элэгдэл	(74,499,822.76)	(112,441,927.96)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	45,101,462.75	48,100,462.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	(8,604,494.50)	(20,861,540.12)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,004,932.69	58,331,355.19
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,475,800.18)	(14,476,755.35)
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,923,300.80	10,923,300.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,728,658.48)	(5,608,543.80)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	139,352,500.00	139,165,000.00
39301	Програм хангамж	525,000.00	525,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(112,500.00)	(300,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	138,940,000.00	138,940,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=II</b>	<b>1,153,773,964.69</b>	<b>1,127,005,459.88</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,153,773,964.69</b>	<b>1,127,005,459.88</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,153,773,964.69	1,127,005,459.88
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	348,593,850.57	348,593,850.57
51101	Өмч: - төрийн	348,593,850.57	348,593,850.57
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	121,684,771.47	94,916,266.66
51210	Өмнөх үеийн үр дүн	121,684,771.47	121,684,771.47
51220	Тайлант үеийн үр дүн	-	(26,768,504.81)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	683,495,342.65	683,495,342.65
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,153,773,964.69</b>	<b>1,127,005,459.88</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл ₮	Тайлант оны гүйцэтгэл ₮
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	926,896,716.14	828,628,663.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	26,780,590.14	13,720,363.60
120	Нийтлэг татварын бус орлого	25,780,590.14	13,720,363.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	25,780,590.14	13,720,363.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	25,780,590.14	13,720,363.50
120017	үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		326,422.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		13,393,941.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	900,116,126.00	814,908,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	735,233,400.00	677,608,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	735,233,400.00	677,608,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,574,726.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,574,726.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	150,308,000.00	137,299,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага/	150,308,000.00	137,299,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	937,605,120.18	865,397,168.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	937,605,120.18	865,397,168.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	820,569,856.95	848,186,829.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	516,139,387.81	522,830,120.40
210101	Үндсэн цалин	472,947,758.81	476,942,256.97
210104	Урамшуулал	43,191,629.00	45,887,863.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,655,140.00	68,310,027.72
210201	Тэтгэрийн даатгал	49,147,482.00	47,308,631.75
210202	Тэтгэмжийн даатгал		5,253,495.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,135,376.00	4,199,440.31
210204	Ажилгүйдлийн даатгал	1,033,843.00	1,049,860.06
210205	Эрүүл мэндийн даатгал	10,338,439.00	10,498,600.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	122,521,862.56	134,986,017.20
210301	Гэрэл, цахилгаан	3,799,312.56	3,992,581.20
210302	Түлш, халаалт	103,292,914.00	115,299,700.00
210303	Цэвэр, бохир ус	15,429,636.00	15,693,736.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,995,942.00	21,255,754.54
210401	Бичиг хэрэг	1,097,550.00	745,600.00
210402	Тээвэр, шатахуун	489,600.00	490,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	742,442.00	2,218,899.94
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	726,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,244,220.00	6,178,387.00
210408	Бараа материал актальсны зардал	14,696,130.00	11,022,867.60
2106	Нормативт зардал	43,307,358.00	32,846,594.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	417,750.00	889,800.00
210502	Хоол, хүнс	42,889,608.00	31,956,794.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	9,876,624.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	9,876,624.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	796,000.00	1,248,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	240,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	1,008,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,154,166.58	56,833,691.31
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	496,000.00	566,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,658,166.58	56,267,491.31
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	116,935,263.23	7,210,339.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,824,645.00	3,279,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,574,726.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,249,919.00	3,279,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	22,786,137.44	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,786,137.44	
2136	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	76,324,480.79	3,931,339.14
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	76,324,480.79	3,931,339.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(11,608,404.04)	(26,768,604.81)
6	НИЙТ ҮР ДҮН (6)=(3)+(4)	(11,608,404.04)	(26,768,604.81)

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	348,593,850.57	683,495,342.65	121,684,771.47	0.00	1,153,773,964.69
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>348,593,850.57</b>	<b>683,495,342.65</b>	<b>121,684,771.47</b>	<b>0.00</b>	<b>1,153,773,964.69</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	348,593,850.57	683,495,342.65	121,684,771.47	0.00	1,153,773,964.69
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	348,593,850.57	683,495,342.65	121,684,771.47	0.00	1,153,773,964.69
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>348,593,850.57</b>	<b>683,495,342.65</b>	<b>121,684,771.47</b>	<b>0.00</b>	<b>1,153,773,964.69</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын жөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-26,768,504.81	0.00	-26,768,504.81
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	348,593,850.57	683,495,342.65	94,916,266.66	0.00	1,127,005,459.88

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	900,116,126.00	814,908,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	885,541,400.00	814,908,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	735,233,400.00	677,608,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	735,233,400.00	677,608,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,574,726.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	150,308,000.00	137,299,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	150,308,000.00	137,299,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	890,776,226.00	793,909,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	890,776,226.00	793,909,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	773,840,962.77	786,698,960.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	516,149,928.21	522,819,572.00
210101	Үндсэн цалин	473,164,499.06	476,931,708.57
210104	Урамшуулал	42,985,429.15	45,887,863.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,655,140.00	68,310,035.72
210201	Тэтгэврийн даатгал	49,147,482.00	47,310,529.06
210202	Тэтгэмжийн даатгал	-	5,253,022.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,135,376.00	4,199,062.14
210204	Ажилгүйдлийн даатгал	1,033,843.00	1,049,765.26
210205	Эрүүл мэндийн даатгал	10,338,439.00	10,497,656.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	122,521,862.56	134,986,017.20
210301	Гэрэл, цахилгаан	3,799,312.56	3,992,581.20
210302	Түлш, халаалт	103,292,914.00	115,299,700.00
210303	Цэвэр, бохир ус	15,429,636.00	15,693,736.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,110,912.00	11,251,689.94
210401	Бичиг хэрэг	1,099,550.00	1,099,600.00
210402	Тээвэр, шатахуун	489,600.00	490,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	742,442.00	2,218,899.94
210404	Ном, хэвлэл	199,000.00	198,890.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	726,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,854,320.00	6,844,300.00
2105	Нормативт зардал	54,013,120.00	33,300,996.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	410,000.00	1,049,400.00
210502	Хоол, хүнс	37,193,120.00	32,161,596.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	16,410,000.00	90,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	1,999,950.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	1,999,950.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	796,000.00	1,248,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	240,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	1,008,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,594,000.00	12,782,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,594,000.00	12,782,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	116,935,263.23	7,210,339.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,824,645.00	3,279,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,574,726.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,249,919.00	3,279,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	22,786,137.44	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,786,137.44	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	76,324,480.79	3,931,339.14
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	76,324,480.79	3,931,339.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	9,339,900.00	20,999,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,339,900.00	20,999,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,339,900.00	20,999,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,339,900.00	20,999,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,339,900.00	20,999,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(9,339,900.00)	(20,999,000.00)

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2.00	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	814,908,300.00	810,976,960.86
21.00	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	814,908,300.00	810,976,960.86
210.00	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	811,628,300.00	807,697,960.86
2,101.00	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	524,808,000.00	522,819,572.00
210,101.00	Үндсэн цалин	478,489,000.00	476,931,708.57
210,104.00	Урамшуулал	46,319,000.00	45,887,863.43
2,102.00	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	68,824,300.00	68,310,035.72
210,201.00	Тэтгэврийн даатгал	46,802,400.00	47,310,529.06
210,202.00	Тэтгэмжийн даатгал	5,505,500.00	5,253,022.44
210,203.00	ҮОМШӨ-ний даатгал	4,404,400.00	4,199,062.14
210,204.00	Ажилгүйдлийн даатгал	1,101,100.00	1,049,765.26
210,205.00	Эрүүл мэндийн даатгал	11,010,900.00	10,497,656.82
2,103.00	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	135,299,700.00	134,986,017.20
210,301.00	Гэрэл, цахилгаан	4,300,000.00	3,992,581.20
210,302.00	Түлш, халаалт	115,299,700.00	115,299,700.00
210,303.00	Цэвэр, бохир ус	15,700,000.00	15,693,736.00
2,104.00	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,455,300.00	11,251,689.94
210,401.00	Бичиг хэрэг	1,100,000.00	1,099,600.00
210,402.00	Тээвэр, шатахуун	490,000.00	490,000.00
210,403.00	Шуудан, жолбоо, интернэтийн төлбөр	2,420,000.00	2,218,899.94
210,404.00	Ном, хэвлэл	200,000.00	198,890.00
210,405.00	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	600,000.00
210,406.00	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,645,300.00	6,644,300.00
2,105.00	<b>Нормативт зардал</b>	33,943,000.00	33,300,996.00
210,501.00	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,050,000.00	1,049,400.00
210,502.00	Хоол, хүнс	32,793,000.00	32,161,596.00
210,503.00	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,000.00	90,000.00
2,106.00	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	23,000,000.00	22,998,950.00
210,601.00	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.00	2,999,000.00
210,602.00	Тавилга	18,000,000.00	18,000,000.00
210,604.00	Урсгал засвар	2,000,000.00	1,999,950.00
2,108.00	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,498,000.00	1,248,000.00
210,801.00	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	490,000.00	240,000.00
210,802.00	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	1,008,000.00
2,109.00	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	12,800,000.00	12,782,700.00
210,902.00	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,800,000.00	12,782,700.00
213.00	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	3,280,000.00	3,279,000.00
2,132.00	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	3,280,000.00	3,279,000.00
213,209.00	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,280,000.00	3,279,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	814,908,300.00	810,976,960.86
1,310.00	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	677,608,600.00	673,990,993.66
131,007.00	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	677,608,600.00	673,990,993.66
1,320.00	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	137,299,700.00	136,985,967.20
132,001.00	Орон нутгийн төсвөөс	137,299,700.00	136,985,967.20

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Есөнбулаг сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Монголиан бизнес рейтинг аудит” ХХК-ний Говь-Алтай салбарын захирал, аудитор Р.Цанжидмаа гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Есөнбулаг сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 03 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх, хүүхдийг бие бялдрын хувьд эрүүл чийрэг өсгөж хөгжүүлэх ариун цэвэр эрүүл ахуйн зөв дадал хэвшилтэй болгох, хэл яриа сэтгэхүйн чадвар эзэмшүүлэх хүрээлэн байгаа орчин юмс үзэгдлийн талаар анхны мэдэгдэхүүнтэй болгох.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Есөнбулаг сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт орлого 925.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 18.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 14.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатны материаллаг байдлыг тайлант оны нийт орлого 828.6 сая төгрөгөөс 2 хувиар тооцож шинэчлэн тогтоосон материаллаг байдал 16.6 сая төгрөг, шинэчлэн тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдал 13.2 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Есөнбулаг сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2.3 хувиар буюу 26.8 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 143.5 сая төгрөг болж 8.2 сая төгрөгөөр өссөн нь хангамжийн материал, тусгай зориулалтын материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 56.3 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 13.1 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 49.3 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,137.3 сая төгрөг болж 21.7 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 21.0 сая төгрөг, Боловсрол соёлын урлагийн газраас 0.2 сая төгрөгийн, Дэлхийн зөн Олон Улсын байгууллагаас 0.3 сая төгрөгийн, НҮБ-ийн хүүхдийн сангаас 8.9 сая төгрөгийн, багш, эцэг эхчүүдийн хандиваар 3.9 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй орлого авсан.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,127.0 сая төгрөг болж 26.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 10.1 хувиар буюу 97.5 сая төгрөгөөр буурсан нь 11.0 сая төгрөгийн бараа материал акталсантай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 94.9 сая төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,077.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 262.1 сая төгрөгөөр бууруулж, 814.9 сая төгрөгөөр баталжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 814.9 сая төгрөгийн төсөв баталснаас 677.6 сая төгрөгийг улсын төсвөөс 137.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 677.6 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 137.3 сая төгрөг, нийт 814.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 811.0 сая төгрөгийг зарцуулж 3.6 сая төгрөгийг улсын төсөвт, 0.3 сая төгрөгийн орон нутгийн төсөвт тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 811.0 сая төгрөг буюу 99.5 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 2.0 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 0.5 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 0.3 сая төгрөгөөр хангамж, бараа материалын зардлыг 0.2 сая төгрөгөөр, нормативд зардлыг 0.6 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 0.2 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

#### **3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

#### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

##### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим системд 1,561.1 сая төгрөгийн 148 мэдээллийг шилэн ил тод байршуулахаас 1,561.1 сая төгрөгийн 148 мэдээллийг ил тод байршуулснаас 18.0 сая төгрөгийн 1 мэдээллийг хугацаа хоцруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1.9 сая төгрөгийн төлбөрийн акт, 14.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн жилийн аудитаар

- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан үндсэн хөрөнгийн чанар, ашиглалтын байдлыг үзэх

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.2 сая төгрөгийн алдааг залруулж, 0.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад Дэлхийн зөн Монгол Олон Улсын байгууллагаас нийлүүлсэн хөрөнгийг орлого аваагүй 0.2 сая төгрөгийн алдааг залрууллаа.

### 4.2 Төлбөрийн акт

Багш нарын үр дүнгийн урамшууллыг 0.8 сая төгрөг дутуу олгосон нь ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.3-т "Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сургалтын байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргээ гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй багш, туслах багш, бусад албан хаагчид олгоно", 4.7-т "Энэ журмын 4.3-т заасан нөхцөлийг хангасан багш, албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг тухайн сургалтын байгууллагын эрхлэгч, захирал гаргана" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэддлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

### 4.3 Албан шаардлага

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь: Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын 1.1-д" Үндсэн үйл ажиллагаатай холбоотой , зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсвөөс , арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн

хэмнэлт гаргахаар тооцож , урсгал, болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөж хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

#### 4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөөгүй .

#### Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Есөнбулаг сумын 1 дүгээр цэцэрлэг	3	1.0	1	0.2	1	0.8	1			
	Дүн	3	1.0	1	0.2	1	0.8	1			